

OCTOBER 20, 2017

ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ГЭМТ ХЭРГЭЭС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН



Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар

Үндэсний Аудитын газрын нэгдсэн
төлөвлөгөө, удирдамжийн дагуу
хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГУУДЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН ҮАГ-ГАГ/2017/09-ГА/



Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах
салбар зөвлөлийн төлөвлөгөө бүрэн хэрэгжээгүй байна.

Чойбалсан хот

2017 он

Агуулга

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Тайланг бэлтгэсэн:
Дорнод аймаг дахь Төрийн
аудитын газрын
Гүйцэтгэлийн аудитын алба

Даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч Б.Болортуул
Утас: 70584203

Аудитын менежер
В.Цэнгэлмаа
Утас: 70584207

Ахлах аудитор
Б.Дэлгэрмаа
Утас: 70584207

Аудитор
М.Ухаанбилэг,
Я.Зориг
Утас: 70584207

2017 оны 10 дугаар сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70584207 дугаарын утас,
70584203 дугаарын
факсаар харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг,
Хэрлэн сум, 7-р баг,
аймгийн ЗДТГ-ын 2-р
байр, 2 давхар 04 тоот

I.I Бүлэг. Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2015, 2016 оны ажлын ерөнхий төлөвлөгөөнд гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох чиглэлийн ажлууд тусгагдаагүй байна.

1.1.1. Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2015, 2016 оны ажлын ерөнхий төлөвлөгөөнд гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох чиглэлийн ажлууд тусгагдаагүй байна.

1.1.2. Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээнүүдийг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

1.1.3. Хорих ял эдлээд суллагдсан иргэдэд Цагдаагийн газар, Прокурорын газрууд нь чиг үүргийнхээ дагуу захиргааны хяналтыг тогтоож, нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

1.1.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгжийг татан оролцуулж байгаа ч ГХУС тухай хуулийн дагуу шагнаж урамшуулахгүй байна.

1.1.5. Нийт ажлын 42-62 хувь сургалт, сурталчилгааны ажлууд байгаа нь хангалттай түвшинд байна.

I.II Бүлэг. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн төлөвлөгөө бүрэн хэрэгжээгүй байна.

1.2.1. ГХУС ажлын арга хэлбэрийг өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нэмэгдүүлэх шаардлагатай байна.

1.2.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа уялдаа холбоо давхардсан болон орхигдуулсан чиг үүрэг байхгүй байна.

1.2.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн төлөвлөгөө бүрэн хэрэгжээгүй байна.

I.III Бүлэг: Хамтран ажилласан зарим байгууллагуудтай хийсэн гэрээний биелэлтийг дүгнээгүй байна.

1.3.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг холбогдох хуулийн дагуу батлаагүй байна.

1.3.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөв, санхүүжилт нь Төсвийн тухай хуулийн 22.6.4 дэх заалттай нийцэхгүй байна.

1.3.3 Хамтран ажилласан зарим байгууллагуудтай хийсэн гэрээний биелэлтийг дүгнээгүй байна.

1.3.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хөндлөнгийн хяналт үр дүнтэй байна.

ДҮГНЭЛТ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН ХАРИУ

ЗӨВЛӨМЖ

ТУШААЛ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ГХУС	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ТББ	Төрийн бус байгууллага
ШШГА	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2017 оны “Аудитын ажлын төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуульд заасан Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Аудитаар Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудын дагуу аудит хийлээ.

1. *Хууль сахиулах байгууллагууд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх;*
2. *Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэр үр дүнтэй эсэх;*
3. *Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсвийн хөрөнгө үр ашигтай зарцуулагдаж буй эсэх.*

Аудитын хамрах хүрээ

Аудитад аймгийн ИТХ, ЗДТГ, Прокурор болон Цагдаагийн газар, бусад холбогдох төрийн байгууллагууд хамрагдлаа.

Үндсэн мэдээлэл:

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, тус зөвлөлийн ажиллах журмыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 81 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан байна. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд орон нутгийн төсвөөс 2015 онд 46,6 сая төгрөг, 2016 онд 68,5 сая төгрөг, 2017 онд 67,7 сая төгрөгийг зарцуулахаар тус тус баталсан байна.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Гүйцэтгэлийн аудитын удирдамж, (АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, журамд заасны дагуу аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүд, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга авах, зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх, түүвэрчлэн шалгах зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

- *Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль;*

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх журам;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр;
- Цагдаагийн албаны тухай хууль;
- Прокурорын тухай хууль;
- Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Захиргааны хариуцлагын тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Замын хөдөлгөөний дүрэм;
- Иргэний хууль;
- Эрүүгийн хууль ;
- Прокурорын байгууллагын тухай хууль;
- Гэр бүлийн тухай хууль;
- Гэр бүлийн хүчирхийлэлийн тухай хууль;
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль;
- “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр”-ийн төлөвлөгөө.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Болортуул удирдаж, аудитын менежер В.Цэнгэлмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Б.Дэлгэрмаа, аудитор М.Ухаанбилэг, Я.Зориг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хугацаа

Аудитыг 2017 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр эхэлж, 10 дугаар сарын 20-ны өдөр дуусган дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газар болон аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хүргүүлэв.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын хариу, аудитын зөвлөмж хэсгүүдээс бүрдлээ.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурдсан 3 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай, зохистой хэмжээгээр орууллаа.

Аудитын тайланг шалгадагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуллаа.

I.I Бүлэг. Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2015, 2016 оны ажлын ерөнхий төлөвлөгөөнд гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох чиглэлийн ажлууд тусгагдаагүй байна.

1.1.1. Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2015, 2016 оны ажлын ерөнхий төлөвлөгөөнд гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох чиглэлийн ажлууд тусгагдаагүй байна.

Дорнод аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2015, 2016 оны ажлын ерөнхий төлөвлөгөө, тайланд зөвлөлөөс гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, судалгаа

шинжилгээ хийх талаар тусгагдаагүй байгаа нь ГХУСТ хуулийн 16.3.6¹ дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна. Харин ГХУСАЗСЗ-ийн гишүүн байгууллагууд болох аймгийн Прокурорын газар, Цагдаагийн газраас энэ чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Аймгийн Цагдаагийн газар нь Цагдаагийн албаны тухай хуулийн 10.1.1² дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2015 оноос өөрийн санаачилгаар гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгуулах, судалгаа, шинжилгээ хийх зорилго бүхий Криминологи судалгааны багийг ажиллуулж байна.

Гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээний чиглэлийг тогтоохдоо аймгийн Цагдаагийн газраас 2 чиглэлээр судалгаа, шинжилгээ хийж байна.

1. Мөрдөн байцаах тасгийн даргаар ахлуулсан 10 хүний бүрэлдэхүүнтэй Криминологи судалгааны баг нь 7 хоног, сар, улирлаар гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцөлийг судалж, дүн шинжилгээ хийн аль сум, багийн нутаг дэвсгэрт ямар гэмт хэргийн тоо өссөн, буурсан үзүүлэлттэй байна, хаана, хэзээ, ямар этгээд, хэдэн цагийн үед үйлдсэн зэрэг мэдээллийг төрөл бүрээр гаргадаг байна.
2. Цагдаагийн газрын судалгаа, мэдээллийн санд объект, субъектийн судалгаанд баяжилт хийн судалгаа мэдээллийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил болон үйлдэгдээд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэргийг илрүүлэхэд ашиглаж байна.

Аймгийн Цагдаагийн газрын Криминологи судалгааны багаас гэмт хэргийн байдалд дүн шинжилгээ хийж, статистик мэдээ, дүн шинжилгээний материалд үндэслэн цаашид тухайн баг, сумын хэмжээнд ямар арга хэмжээ авч ажиллах талаар зөвлөмж, чиглэл боловсруулж, холбогдох алба, тасгийн удирдлага, албан тушаалтнуудад хүргүүлэх зэрэг ажилбарууд хийгдэж байна.

Аймгийн Прокурорын газар нь Монгол Улсын Ерөнхий прокурорын 2017 онд баталсан А/87 дугаар “Прокурор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оролцох аргачилсан заавар”-ын 2.1.3³ -д заасны дагуу гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судалж, 2015-2016 оны байдлаарх үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил, эрүүгийн нөхцөл байдлыг судалсан судалгааны дүнг гаргаж, аймгийн ГХУСАЗСЗ болон Засаг даргад хүргүүлэн ажилласан байна.

Аймгийн Прокурорын газраас Прокурорын тухай хуулийн 36.1⁴ дэх заалтыг хэрэгжүүлэх, гэмт хэрэг, зөрчил гарах болсон шалтгаан нөхцөлийг арилгуулах, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх чиглэлээр 2015-2017 оны хагас жил хүртэлх хугацаанд прокурорын нийт 105 мэдэгдэл /2015 онд 45, 2016 онд 37, 2017 оны хагас жилд 23 мэдэгдэл/ бичиж биелэлтийг нь хуулийн хугацаанд нь тооцож ажилласан байна.

1.1.2. Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээнүүдийг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

¹ “Зохицуулах зөвлөл нь гэмт хэргийн байдалд хамтран дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээний чиглэлийг тогтоох”

² “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгуулах;”

³ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр судалгаа хийх,

⁴ 36.1. Прокурор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулах мэдэгдэл бичнэ.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн жилийн ажлын ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа Цагдаагийн газар, Прокурорын газар, Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн алба, Хэрлэн сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, төрийн бус байгууллагуудаас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөгөөнд тусгуулах саналыг авч, жилийн төлөвлөгөөг боловсруулж байна.

ГХУС чиглэлээр ерөнхий төлөвлөгөөнд оруулахаар 2015 онд ирүүлсэн аймгийн Прокурорын газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн 5 ажлын саналаас 3-ыг, Цагдаагийн газрын 42 ажлын саналаас 19-ыг, Онцгой байдлын хэлтийн 6 ажлын саналаас 3-ыг, ШШГА-ны 3 ажлын саналаас 1-ийг, МХГ-ын 5 ажлын саналаас 2-ыг, ТЕГ-ын Дорнод аймаг дахь газрын 2 ажлын саналаас 2-ыг, Хүүхэд, гэр бүл, хөгжлийн хэлтсийн 7 ажлын саналаас 4-ийг тус тус төлөвлөгөөнд тусгасан байна. Нийт гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн 74 ажлын санал ирүүлснээс давхардсан тоогоор 34 ажлын саналыг төлөвлөгөөнд тусгасан байна.

Аймгийн Цагдаагийн газрын Криминологи судалгааны багаас хийсэн судалгаа, шинжилгээний дүнгээс үзэхэд 2015-2017 онд нийт гэмт хэргийн гаралт 6,5 - 8,9 хувиар буурсан ч зарим тодорхой төрлийн гэмт хэргүүд өссөн үзүүлэлттэй гарсан байна. /Үүнд: малын хулгай, иргэдийн өмчийн хулгай, залилах, зам тээврийн осол, булаах, дээрэмдэх, танхайрах, хүчиндэх гэмт хэргүүд 1-14 нэгжээр өссөн./ Малын хулгай, иргэдийн өмчийн хулгай, зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрөл бүрийн нэгдсэн арга хэмжээ, сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулах талаар ГХУСАЗСЗ-ийн жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлсэн байна. Булаах, дээрэмдэх, танхайрах, хүчиндэх гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Прокурорын газар, Цагдаагийн газрын жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, сургалт, зөвлөгөөн, хяналт шалгалтын нэгдсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажилласан байна.

Гэмт хэргүүдийн өсөлт, бууралтын шалтгаан нөхцөлд 7 хоног бүр судалгаа шинжилгээ хийж, багаас гарсан дүгнэлтийн дагуу ажлын чиглэл, зөвлөмжийг боловсруулан Цагдаагийн газрын холбогдох тасаг, нэгжийн удирдлагуудад өгч, 7 хоног бүрийн аймгийн Удирдах ажилтнуудын шуурхай хуралдаан болон холбогдох албан тушаалтнуудад тухай бүрт танилцуулж ажилласан байна.

ГХУСАЗСЗ-өөс 2017 онд хийж хэрэгжүүлэх ажлын ерөнхий төлөвлөгөөг батлахдаа ГХУСТ хуулийн 5 дугаар зүйл⁵-ийг баримталж нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээнүүдийг дэлгэрэнгүй байдлаар тусгасан байна.

ГХУСАЗСЗ-ийн 2015 оны ерөнхий төлөвлөгөөг 8 бүлэг 32 заалт, 2017 оны ерөнхий төлөвлөгөөг 9 бүлэг 68 заалттай байхаар тус тус баталжээ.

Харин 2016 онд ажлын 2 ерөнхий төлөвлөгөө /ИТХ-ын хурлын дарга солигдсонтой холбогдуулан ГХУСАЗСЗ-ийн дарга Р.Зоригтбаатарын баталсан 8 бүлэг 30 заалттай төлөвлөгөө, ГХУСАЗСЗ-ийн дарга П.Мөнхтөрийн баталсан 8 бүлэг 23 заалт бүхий төлөвлөгөө/-г баримтлан ажилласан байна. Төлөвлөсөн ажлуудын

⁵ 5 дугаар зүйл. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэл

5.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг дараахь үндсэн чиглэлээр зохион байгуулж хэрэгжүүлнэ:

5.1.1. гэмт хэргийн талаархи мэдээллийг цуглуулж, судалгаа, дүн шинжилгээ хийх замаар түүний гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох;

5.1.2. гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүйн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх;


5.1.3. давтан гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор хорих ял эдлээд суллагдсан хүнд энэ хуульд заасан журмын дагуу захиргааны хяналт тогтоох;

5.1.4. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгж, байгууллагыг өмчийн хэлбэр харгалзахгүй татан оролцуулах;

5.1.5. гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах.

төсөвт эзлэх хувийг авч үзвэл:

Дүрслэл №1. “Батлагдсан төсвийн ангилал, 2015-2017 он”



ГХУСАЗСЗ-ийн 2015-2017 онд хэрэгжүүлэх нийт төсвийн 62,0 хувийг сургалт, сурталчилгаа, , хяналт шалгалт явуулах ажилд 14,0 хувийг, бусад /ГХУСАЗСЗ-ийн үйл ажиллагаа, дэмжлэг, урамшуулал зэрэг/ арга хэмжээнд 24,0 хувийг тус тус төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

1.1.3. Хорих ял эдлээд суллагдсан иргэдэд Цагдаагийн газар, Прокурорын газрууд нь чиг үүргийнхээ дагуу захиргааны хяналтыг тогтоож, нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

Аймгийн Цагдаагийн газар нь ГХУС тухай хуулийн 15 дугаар зүйл⁶-д заасан захиргааны хяналтыг тогтоож ажиллаж байна. 2017 оны 06 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд хорих ял эдлээд суллагдсан нийт 125 ялтныг бүртгэлээр хүлээн авч, хүн бүр дээр 20 төрлийн материал бүрдүүлэн хувийн хэрэг нээн хариуцсан нутаг дэвсгэрийн хэсгийн байцаагч, хэсгийн төлөөлөгч нарт материалын хамт хүргүүлэн захиргааны хяналт тавин ажиллажээ.

Эдгээр иргэдийг сар бүрийн 15-ны өдрийн 15 цагт цагдаагийн газрын хурлын зааланд цуглуулан архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж улмаар гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байх чиглэлээр “Баталгаа” гаргуулан авч, аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албатай хамтран “Хорих ялыг биечлэн эдлүүлэх ажиллагаа”, “Дахин гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх, түүнд нөлөөлөх сэтгэл зүй” сургалт, “Эдгэрлийн баяр хөөр”, “Архины хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх нь” зэрэг хичээл сургалтыг зохион байгуулан ажилласан байна.

Нийгэмшүүлэх ажлын хүрээнд аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран хорихоос суллагдсан, хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй, гэр оронгүй тэнэмэл иргэд, архинаас татгалзсан иргэдийг нийгэмшүүлэх, ажил мэргэжилтэй, гэр оронтой болоход нь дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд иргэний цахим үнэмлэх авч байгаагүй болон гээгдүүлсэн гэх 10 иргэнийг бичиг баримттай болгох ажлыг зохион байгуулсан байна.

⁶ “Хорих ял эдлээд суллагдсан хүнд захиргааны хяналт тогтоох” 15.1-15.11 бүх заалтууд хамаарна.

Хорих ял эдлээд суллагдсан иргэд дахин тухайн төрлийн гэмт хэрэг үйлдсэн тохиолдол 2017 оны 06 дүгээр сарын байдлаар гараагүй байна. Хорихоос бүр мөсөн ял нь дуусч, суллагдсан иргэдийн хувьд тухайн хорих байгууллагаас мэдээлэл нь ирсний дагуу бүртгэж авч, нийгэмшүүлэх арга хэмжээ зохион байгуулсан байна.

Аймгийн Прокурорын газар нь Прокурорын тухай хуулийн 22.1.1⁷, 24.13⁸-д заасны дагуу Цагдаагийн газарт хяналт шалгалтыг хийж, шаардлагатай тохиолдолд холбогдох албан тушаалтанд шаардлага бичиж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

Тус шалгалтаар хорихоос хугацаанаас өмнө суллагдсан, чөлөөлөгдсөн, гэмт хэрэг үйлдэж, таван жилээс дээш хугацаагаар хорих ял эдэлсэн хүн хорих ял эдэлж суллагдсан, хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй этгээдүүдийн хувийн хэрэг, материалд хийсэн шалгалтаар ялтны материалыг шалгалтад бүрэн хамруулаагүй, хяналтын хугацаанаас хэтрүүлж танилцуулсан, алслагдсан 13 сумын хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэйтэй иргэдэд тавих хяналт сул гэсэн дүгнэлтийг гаргаж, холбогдох албан тушаалтнуудад шаардлага хүргүүлсэн байна. Шаардлагын хариуг Цагдаагийн газраас холбогдох албан тушаалтнуудаас тайлбар, баталгаа гаргуулж авч, тухай бүрт нь биелэлтийг гаргуулан ажилласан байна.

1.1.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгжийг татан оролцуулж байгаа ч ГХУС тухай хуулийн дагуу шагнаж урамшуулахгүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгжийг татан оролцуулах ажлыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12.1⁹, 12.1.1¹⁰, 12.1.2¹¹, 13.1¹², 13.2¹³, 19.3.2¹⁴, 19.3.3¹⁵ дахь заалтуудаар тус тус зохицуулагдсан байна.

ГХУСАЗСЗ-ийн журамд зөвлөлийн эрх, үүрэгт “Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах, сахилга зохион байгуулалтыг сайжруулах, архидан согтуурах, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, төрийн болон төрийн бус байгууллагын үүсгэл санаачилгыг дэмжин ажиллана”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэгтэй тэмцэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг шагнаж урамшуулна” гэж заасан байна.

Дээрх заалтуудын дагуу ГХУС ажилд давхардсан тоогоор 2015 онд 5000 иргэн, 254 аж ахуйн нэгж, 2016 онд 10428 иргэн, 265 аж ахуйн нэгж, 2017 онд 10000 иргэн, 275 аж ахуйн нэгжийг тус тус татан оролцуулсан байна.

Аймгийн Цагдаагийн газар нь олон нийтийн цагдаагийн урамшуулалд 2016 онд 2,2 сая төгрөг, 2017 оны эхний хагас жилд 3,2 сая төгрөг нийт 5,4 сая төгрөгийг зарцуулжээ. Үүнээс 1,2 сая төгрөгийг 2016 оны ГХУСАЗСЗ-ийн төсвөөс зарцуулсан байна. Энэ нь нийт 2015-2017 оны төсвийн 1,0 хувийг эзэлж байгаа нь бага байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, аж ахуйн нэгжийг татан

⁷ хорих, хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх, тэнсэх, албадлагын арга хэмжээ биелүүлэх ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэх;

⁸ хорих болон хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн этгээдийн хувийн хэрэг, материалтай танилцах, хянах;

⁹12.1. “Нутгийн захиргааны байгууллага харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахдаа иргэдийг дараахь хэлбэрээр татан оролцуулна”

¹⁰12.1.1 “иргэдийг нийтийн эргүүлд гаргах”

¹¹12.1.2 “хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрээр томилох”

¹²13.1. “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэнийг дор дурдсан хэлбэрээр урамшуулна”,

¹³13.2. “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар тодорхой ажил зохиож, үр дүнд хүрсэн байгууллага, аж ахуйн нэгжийг нутгийн захиргааны болон цагдаагийн байгууллага дор дурдсан хэлбэрээр урамшуулна”,

¹⁴19.3.2. “энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан эргүүл, жижүүр, олон нийтийн цагдаагийн ажилтныг урамшуулах”,

¹⁵19.3.3. “энэ хуулийн 13 дугаар зүйлд зааснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг шагнаж, урамшуулах”

оролцуулж байгаач урамшуулах хөшүүрэг бага байгаа нь цаашид иргэд, аж ахуйн нэгжийн оролцох идэвх санаачлага, ажлын үр дүн буурахад нөлөөлөх тул урамшууллыг өгч ажиллах шаардлагатай байна.

1.1.5. Нийт ажлын 42-62 хувь сургалт, сурталчилгааны ажлууд байгаа нь хангалттай түвшинд байна.

ГХУС-тэй холбогдсон хууль тогтоомжийг иргэдэд мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах чиглэлээр 2015-2017 онд нийт төсвийн 62,0 хувийг төлөвлөж, баталсан байна. Хууль тогтоомжийг иргэдэд мэдээлж, сурталчлах, нөлөөллийн ажил зохион байгуулах чиглэлээр 2015 онд нийт ажлын 62,0 хувь, 2016 онд 56,0 хувь, 2017 онд 42,0 хувь байгаа нь хангалттай түвшинд байна.

Аймгийн Прокурорын газраас 2015-2017 оны эхний хагас жил хүртэлх хугацаанд 110 аж ахуйн нэгж байгууллагын 9373 хүнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан байна. Аймгийн Цагдаагийн газар, Шүүх, ШШГА, Хүүхэд, гэр бүл, хөгжлийн хэлтэс, Хэрлэн сумын ЗДТГ, төрийн бус байгууллагуудаас шинээр гарсан хууль тогтоомжийн хэрэгжилт, архины, тамхины хор хөнөөл, хулгайн гэмт хэрэг /мал, иргэдийн өмчийн/, замын хөдөлгөөний аюулгүй байдал, авлигын эсрэг, насанд хүрээгүй иргэд, хүүхдэд зориулсан, байгаль орчны гэмт хэрэгтэй холбоотой олон төрлийн сургалтуудыг зохион байгуулсан байгаа ч хамрагдсан иргэдийн тоог нэгтгэх боломжгүй байна.

Аймгийн хэмжээнд 2015 онд бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 37 нэгжээр буюу 6,5 хувь, 2016 онд бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 47 нэгжээр 8,9 хувь, 2017 оны эхний хагас жилд бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 19 нэгжээр буюу 7,2 хувь, 2015 оноос хойш нийт 103 буюу 22,6 хувиар буурсан нь хууль тогтоомжийг иргэд, олон нийт, аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлах, сургалт зохион байгуулсан нь зохих нөлөө үзүүлсэн гэж дүгнэж байна.

I.II Бүлэг. ГХУС ажлын арга хэлбэрийг өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нэмэгдүүлэх шаардлагатай байна.

1.2.1. ГХУС ажлын арга хэлбэрийг өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга хэлбэрийг хуульд заасан арга хэлбэрээс гадна нь сургалт, зөвлөгөөн, хяналт шалгалт зохион байгуулах, хөтөлбөр хэрэгжүүлэх зэргээр зохион байгуулсан нь гэмт хэргийн гаралтыг бууруулахад нөлөө үзүүлсэн байна. Тухайлбал:

- Насанд хүрээгүй хүүхдийг зам тээврийн осолд өртөх, гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор “School police”, “Сургуулийн бүс”, “Цэцэрлэгийн бүс”-2 төсөл, арга хэмжээ хэрэгжсэнээр зам тээврийн осол, зөрчил буурч, гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлж байна.
- Зөвлөгөөн, сургалтыг тогтмол зохион байгуулснаар мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн хамтын ажиллагаанд ахиц гарч, малчид, иргэдийн хариуцлага дээшилж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажилд иргэд, олон нийтийн оролцоо нэмэгдсэнээр малын хулгайн хэргийн гаралт буурах үндсэн нөхцөл болж байна.
- “Архигүй амьдрал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Архи-Хяналт”, “Бажу архи-илрүүлэлт”, “Архи шаг”, “Зөвшөөрөлгүй архи спирт-илрүүлэлт”, “Спирт хяналт”, “Хуурамч акц”, “Спирт илрүүлэлт” зэрэг нийт 72 нэгдсэн болон тусгай хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулж, архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр болон эргүүл хяналтыг зөв оновчтой зохион байгуулснаар 2015, 2016 оны байдлаар согтуугаар үйлдэгддэг гэмт хэрэг 13 нэгжээр буюу 7,8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй “Объект, субъектын судалгаа-эрчимжүүлэлт”, “Дахин алдах эрхгүй”, “Дотуур байр”, “Захиргааны хяналт-судалгаа”, “Хальтиргаа гулгаа”, “Цахим

тоглоом-хяналт”, “Зочид буудал-хяналт”, “Гэрээт харуул хамгаалалтын байгууллага-хяналт судалгаа”, “Газрын тос-Матад хороолол”, “Хулгай оргодол”, “Халамж хяналт”, “Бажу архи-хяналт”, “Шатахуун түгээх станц-хяналт”, “Олон нийтийн эргүүл” “Сар шинэ-мэдэгдэл”, “Манаач ба сэрэмжлүүлэг”, “Интернет, цахим тоглоомын газар-хяналт шалгалт”, “Харуул манаа”, “Захиргааны хяналт- зааварчилга”, “Иргэдийн өмчийн хулгай”, “Шөнийн эргүүл”, “Камерын хяналт”, “Гэр бүлийн хүчирхийллийн хууль ба олон нийтийн оролцоо”, “Оюутан эргүүл”, “Архи-хяналт”, “Тамхи –хяналт”, “Хамгаалах бүс”, “Өвлийн дугуй-хяналт”, “Хөдөлгөөний соёл”, “Бичиг баримт-хяналт шалгалт”, “Нийтийн тээвэр-хальтаргаа гулгаа”, “Ачаа тээш”, “Цагдаа-хяналт”, “Тээврийн хэрэгсэл-өнгө үзэмж”, “Эвдрэл гэмтэл-техникийн байдал”, “Хөдөлгөөн-хяналт”, “Ачааны авто машин-ачаа тээвэрлэлт”, “Мотоцикл-хяналт”, “Март-хяналт”, “Монгол цэргийн өдөр-хяналт”, “Ачаа тээш-согтуу илрүүлэлт”, “Зах хяналт”, “Хууль бус архи-илрүүлэлт”, “Архины зөвшөөрөл-хяналт”, “Эрчимжүүлсэн хяналт”, “Хөдөлгөөний хяналт”, “Танд баярлалаа”, “Оюутан тээвэр”, “Цэрэг татлага”, “Улсын дугаар”, “Баян-Уул хяналт”, “Халхгол хяналт”, “Мотоцикл хяналт”, “Иргэдийн аюулгүй зорчих эрх” зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.

Аймгийн ГХУС ажил нь дээрх арга хэлбэрүүдээр зохион байгуулагдаж байгаа нь өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх талаар ГХУСАЗСЗ, Цагдаа, Прокурорын газрын холбогдох албан тушаалтнуудтай хийсэн уулзалт, ярилцлага, судалгаа шинжилгээний үр дүнгээс нийгэмд хэрэгцээтэй дараах арга хэмжээг нэмэгдүүлж ажиллах нь шаардлагатай байна. Үүнд:

- Олон нийтийн цагдааг нэмэгдүүлэх /Орон нутгийн төсөвт тусгах/
- Чойбалсан хотын хэмжээнд байгаа камеруудын тоог нэмэгдүүлж, бүрэн бүтэн байдал, хэвийн ажиллагааг хангах
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийт, аж ахуйн нэгж байгууллагуудын оролцоог хангаж, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.

1.2.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа уялдаа холбоо давхардсан болон орхигдуулсан чиг үүрэг байхгүй байна.

Өнгөрсөн онуудад ГХУСАЗСЗ-ийн төсвийг ИТХ-ын дарга өөрөө хуваарилж, зарцуулж гүйцэтгэж ирсэн нь хуулийн дагуу хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх боломжгүй болгож байсан. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 07 дугаар тогтоолоор уг зөвлөлийн ажиллах журамд орсон нэмэлт өөрчлөлтөд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан төсвийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс баталсан төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг дарга хуваарилж зарцуулна” гэсэн заалтыг оруулан хэрэгжүүлж дээрх зөрчлийг арилгасан байна.

1.2.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төлөвлөгөө бүрэн хэрэгжээгүй байна.

Зохицуулах салбар зөвлөл нь 2015 онд 8 бүлэг 32 заалттай төлөвлөгөө баталснаас 28,0 хувь, 2016 онд 8 бүлэг 30 заалттай төлөвлөгөө баталснаас 60,0 хувь нь тус тус хэрэгжсэн байна. 2017 онд 8 бүлэг 25 заалттай төлөвлөгөө баталж 44,0 хувийн хэрэгжилттэй явж байна.

Аймгийн ГХУСАЗСЗ-д 2015 онд 4, 2016 онд 8 сумын зөвлөлөөс ГХУС ажлын тайлан ирүүлсэн байна. Мөн зохицуулах салбар зөвлөл нь ажлын тайланг гишүүн байгууллагуудаас авахдаа төлөвлөгөөний биелэлтээр авдаггүй бичмэл тайлангаар авч нэгтгэн гаргаж байна. Энэ нь хуулийн 16.3.3 дахь “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, биелэлтийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлэхгүй байна.

I.III Бүлэг. ТББ, хэвлэл мэдээлэлийнхэнтэй хамтран ажиллах гэрээний биелэлтийг дүгнэхгүй байна.

1.3.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг холбогдох хуулийн дагуу батлаагүй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээг ГХУС тухай хуулийн 19.1 дүгээр заалтад тодорхой заасан байна. Уг заалтаар шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40,0 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг төсөвлөх ёстой. Төлөвлөсөн дүнг авч үзвэл дараах байдалтай байна.

Он	Суурь орлого	Төлөвлөх дүн	Төлөвлөсөн дүн
2014	138,6	55,4	68,5
2015	195,9	78,4	68,5
2016	324,2	129,7	67,7

Хүснэгтээс харахад 2016, 2017 онуудад 6,1-20,0 хувиар дутуу төлөвлөсөн байна.

1.3.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөв, санхүүжилт нь Төсвийн тухай хуулийн 22.6.4 дэх заалттай нийцэхгүй байна.

Төсвийн тухай хуулийн 22.6.4 дэх заалтад "... тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах," гэж заасан байна. Гэтэл ГХУС тухай хуулинд тодорхой хувиар тогтоож өгсөн нь дээрх хуулийн заалттай нийцэхгүй байна.

ГХУС тухай хуулинд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаанд зориулсан хөрөнгийг зарцуулах зардлуудыг тодорхой зааж өгсөн байна. Гэтэл ИТХТ-ийн тогтоолоор хуульд заагдаагүй зардлын төрлийг журмаар баталж оруулсан байна. Уг журмын нийтлэг үндэслэлд 9 дүгээрт "Зөвлөл нь үйл ажиллагааны зардалтай байна. гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан хөрөнгийн 10,0 хувийг салбар зөвлөлийн үйл ажиллагаанд зарцуулна." гэж тусгасан нь ГХУС тухай хуультай нийцэхгүй байна.

1.3.3 Хамтран ажилласан зарим байгууллагуудтай хийсэн гэрээний биелэлтийг дүгнээгүй байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан 2015-2017 оны зардлын гүйцэтгэлийг шалгахад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн зардлаас 2015 онд "Хатан сэлбэ", "Зорилготой амьдрал", "Зүүн бүсийн хүний эрхийн төв" зэрэг төрийн бус байгууллагуудад нийт 9,1 сая төгрөгийг шилжүүлж хамтран ажиллаж ирсэн гэх боловч хийсэн ажлын гүйцэтгэлийн тайлан байхгүй, 2016 онд орон нутгийн телевиз, хэвлэл мэдээллийн байгууллагуудад 14,0 сая төгрөгийг шилжүүлсэн боловч зарцуулалтын гүйцэтгэлийн тайлан байхгүй, гэрээний биелэлтийг дүгнээгүй байна.

Мөн уг зөвлөлийн төлөвлөгөөнд бусад ажлын хүрээнд гэж заасан зардлаас 2015 онд 4,0 сая төгрөг, 2016 онд 3,0 сая төгрөг нийт 7,0 сая төгрөгийг ГХУСАЗСЗ-ийн зөвлөн туслах, шалган туслах ажлыг зохион байгуулах, бичиг хэрэг, албан хэрэгцээнд notebook, лазер принтер, болзошгүй зардал гэсэн зардлуудыг гаргасан нь төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу, үр ашигтай захиран зарцуулахгүй байгааг харуулж байна.

1.3.4 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хөндлөнгийн хяналт үр дүнтэй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19.5¹⁶ дахь заалтаар зохицуулагдсан байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба 2015 онд хяналт шалгалт, аймгийн Төрийн аудитын газар нь 2015, 2016 онуудад санхүүгийн аудитыг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Аудитын явцад хяналт хийсэн дүгнэлт, хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаарх нотлох баримтуудыг шалгахад дараах байдалтай байна.

Аймгийн Төрийн аудитын газар нь ИТХ нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төсвийг аймгийн ИТХ-ын төсөв дээр нэмж баталж байгаа нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-д “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг аймаг, нийслэлийн батлагдсан төсөв дээр нь нэмж олгох замаар төвлөрүүлж, сум, дүүргийн Засаг даргад гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн байдлыг харгалзан хуваарилж зарцуулна” гэж заасантай нийцэхгүй байна гэсэн албан шаардлага өгсний дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 07 дугаар тогтоолоор уг зөвлөлийн ажиллах журамд нэмэлт өөрчлөлтөөр “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан төсвийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс баталсан төлөвлөгөөний дагуу аймгийн Засаг дарга хуваарилж зарцуулна” гэсэн заалтыг оруулан зарцуулж байна.

Хуулийн дагуу ИТХ нь дээрх зардалд хяналт тавих зохицуулалттай байтал өмнөх онуудад уг төсвийг ИТХ-ын төсөв дээр нэмж баталж, зарцуулж ирсэн байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2015 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж 4 дүгнэлт өгч зарим ажилтныг зохих шатны хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлэх нь зүйтэй гэсэн зөвлөмжийг өгсөн байна.

Аймгийн ИТХ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн нарийн бичгийн даргыг Санхүүгийн хяналт, аудитын албанаас өгсөн зөвлөмж, бусад шалтгааны дагуу ажлаас халсан боловч шүүхийн тогтоолоор эргэж ажилд нь томилон ажиллуулсан байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 81 тоот тогтоолоор Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн бүрэлдхүүнийг шинэчилж тус зөвлөлийн нарийн бичгийн даргаар аймгийн Цагдаагийн газрын даргыг томилсон байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2015, 2016 оны ажлын ерөнхий төлөвлөгөөнд гэмт хэргийн гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох чиглэлийн ажлууд тусгагдаагүй байна.
2. Хорих ял эдлээд суллагдсан иргэдэд Цагдаагийн газар, Прокурорын газрууд нь чиг үүргийнхээ дагуу захиргааны хяналтыг тогтоож, нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

¹⁶19.5 “Хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд тухайн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Төсвийн тухай хууль тогтоомжид заасан эрх бүхий этгээд хяналт тавина.”

3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн болон аж ахуйн нэгжийг татан оролцуулж байгаа ч ГХУС тухай хуулийн дагуу шагнаж урамшуулахгүй байна.
4. Нийт ажлын 42-62 хувь сургалт, сурталчилгааны ажлууд байгаа нь хангалттай түвшинд байна.
5. ГХУС ажлын арга хэлбэрийг өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн нэмэгдүүлэх шаардлагатай байна.
6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа уялдаа холбоо давхардсан болон орхигдуулсан чиг үүрэг байхгүй байна.
7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төлөвлөгөө бүрэн хэрэгжээгүй байна.
8. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг холбогдох хуулийн дагуу батлаагүй байна.
9. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсөв, санхүүжилт нь Төсвийн тухай хуулийн 22.6.4 дэх заалттай нийцэхгүй байна.
10. Хамтран ажилласан зарим байгууллагуудтай хийсэн гэрээний биелэлтийг дүгнээгүй байна.
11. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулагдсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хөндлөнгийн хяналт үр дүнтэй байна.

Аудитаар нийт 30,1 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 8 зөвлөмж өгч ажиллалаа.


МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРАЛ
21000 Чойрхон, Дорнод аймаг
Утас: 3028-4131, 3028-2207
2017.10.19 № 4289
Хэргийн үйл явдлын № _____

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас ирүүлсэн "Хууль сахиулах байгууллагуудын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайланд тусгагдсан зөвлөмжүүдийг зөвшөөрч, цаашид хэрэгжүүлж ажиллах болно.

ДАРГА  Л.ХИШИГТОГТОХ

04 153

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга Л.Хишигтогтоход зөвлөж байна. Үүнд:

1. ГХУСАЗСЗ-өөс гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоох талаарх чиг үүргийг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх.
2. ГХУС тухай хуулийн дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд оролцож байгаа иргэн болон аж ахуйн нэгжийг шагнаж урамшуулах хөшүүргийг нэмэгдүүлэх.
3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлж нэмэгдүүлэх арга хэмжээ авах.
4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төлөвлөгөөг цаашид бүрэн хэрэгжүүлж ажиллах.
5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төсвийг холбогдох хуулийн дагуу төлөвлөж байх.
6. ГХУСАЗСЗ нь ГХУС тухай хуулийн 19.3-т зааснаас бусад зардлыг төлөвлөж, зарцуулахгүй ажиллах.
7. Цаашид ТББ, хэвлэл мэдээлэлийнхэнтэй хамтран ажиллах гэрээний биелэлтийг дүгнэж ажиллах.
8. Аймгийн ИТХ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын санхүүжилтийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах.

Аудитаар тавигдсан зөвлөмжийн биелэлтийг хангуулж 2018 оны 04 дүгээр сарын 05-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.


МОНГОЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 20 өдөр
2017 оны 10 сарын 20 өдөр

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.5 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 121 дүгээр тушаалын 5 дэх заалт, 2016 оны А92 тоот тушаалаар батлагдсан Гүйцэтгэлийн аудитын журам-ын 12.40 дэх заалт, аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөхийн 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Хууль сахиулах байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийн хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор М.Давааням, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга Л.Хишигтөхтөх нэрт хүргүүлсүгэй.
3. Гүйцэтгэлийн аудитаар өссөн зөвлөхийн хэрэгжилтэд хяналт тавьж шиллэхгээ ахлах аудитор Б.Дэлгэрмаад даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮВ
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б.БОЛОРТУУЛ

11 122

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮВ
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б.БОЛОРТУУЛ

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД
АУДИТЫН МЕНЕЖЕР  В.ЦЭНГЭЛМАА

БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР  Б.ДЭЛГЭРМАА
АУДИТОР  М.УХААНБИЛЭГ
АУДИТОР  Я.ЗОРИГ